




ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Дорноговь аймгийн
нийгэм, эдийн засгийн
танилцуулга

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

2018/3



Мэдээллийн нэгдсэн лавлах: WWW.1212.MN

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

(2018 оны 03 дугаар сарын байдлаар)

Нэг. Нийгмийн үзүүлэлт




1.1 Хүн ам

Дорноговь аймгийн хэмжээнд 2018 оны 03 сард 352 эх амаржиж, 352 хүүхэд шинээр мэндэлжээ. Амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үеэс 46(15.0%)-өөр, төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 44(14.3%)-өөр, 90 хүн нас барсан нь 7(8.4%)-аар тус тус өссөн байна.

Хүн амын цэвэр өсөлт 262 болж өмнөх оны мөн үеэс 37(16.4%)-оор өсчээ. 1000 хүнд ногдох төрөлт 5.2, нас баралт 1.3 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 0.5 пунктээр өсч, нас баралт өмнөх оны мөн үетэй адил хэмжээнд байна.

Зураг. Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2015-2018 оны 03 сард



Он гарсаар эхийн эндэгдэл гараагүй бөгөөд нялхсын эндэгдэл 4 байгаа нь өмнөх оны мөн үеэс 1-ээр их байна.



1.2 Эрүүл мэнд


2018 оны 03 сарын байдлаар 87.5 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 3.2 хувиар буурч, 4.6 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 4.5 хувиар өсч, 2.9 мянган хүн урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан нь өмнөх оны мөн үетэй адил хэмжээнд байна.

2018 оны 03 сард 436 эх жирэмсний хяналтанд орсны 85.3 хувь буюу 372 эх жирэмсний эхний 3-н сард хяналтанд хамрагджээ. Жирэмсний хяналтанд хугацаандаа орсон эхийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.3 хувиар буурсан байна.

Түргэн тусламжийн дуудлага 5.4 мянган удаа гарсны мянга буюу 16.7 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт түргэн тусламжийн дуудлага 5.9 хувиар өсч, алсын дуудлага адил хэмжээнд байна.

Он гарсаар ослын улмаас 708 хүн бэртэж, 16 иргэний амь нас энджээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бэртэж гэмтсэн хүний тоо 71 (11.1%)-ээр нэмэгдэж, нас барсан хүний тоо 6(27.3%)-аар буурсан байна.

Зураг. Нас баралт, өвчний шалтгаанаар, хувь. 2018 оны 03 сард



Нас баралтыг өвчний шалтгаанаар авч үзэхэд хавдар 18.2 хувь, цусны эргэлтийн тогтолцооны өвчин 33.3 хувь, амьсгалын тогтолцооны өвчин 12.1 хувь, осол гэмтэл, хордлого гадны шалтгаант нас баралт 18.2 хувь, бусад төрлийн өвчин 18.2 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт өвчний 147 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 160 (52.1%)-аар буурчээ. Халдварт өвчний тохиолдол буурахад сүрьеэ 17.9 хувь, трихоминиаз 64.3 хувь, вирус гепатит 66.7 хувь, бусад төрлийн өвчин 77.9 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

1.3 Соёл

Аймгийн соёл урлагын байгууллагууд эхний 3 сарын байдлаар 11.2 мянган хүнд үйлчилж, 9.0 сая төгрөгийн орлоготой ажиллажээ. Аймагт үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн урлагийн байгууллага 52 удаагийн тоглолт хийж, музейнүүд дотоод, гадаадын 0.9 мянган хүнд үйлчилсэн байна.



1.4 Бүртгэлтэй ажилгүй иргэн


Хөдөлмөрийн хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэд 2018 оны 03 сарын эцэст 696 болсны 687 (98.9%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 9 (1.3%) нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеийнхээс 1015 (59.3 %) хүнээр буурч, өмнөх сараас 344(33.1%) хүнээр буурсан байна. Бүртгэлтэй ажил хайгч иргэдийн 353 (50.7%) нь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 360 (51.7%) нь Сайншанд суманд, 199 (28.6%) нь Замын-Үүд суманд байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн боловсролын түвшинг харахад 56.3 хувь нь бүрэн дунд, 23.9 хувь нь дээд, 7.0 хувь нь техник болон мэргэжлийн, 5.0 хувь нь бүрэн бус дунд, 4.9 хувь

нь тусгай дунд, 0.9 хувь нь бага, 1.9 хувь нь боловсролгүй, 0.1 хувь нь магистр/докторын боловсролтой иргэд эзэлж байна.


Зураг. Ажилгүй иргэдийн тоо, боловсролоор, хувиар, 2018 оны 03-р сард




Хөдөлмөрийн хэлтэст он гарсаар 1005 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 58 иргэн ажилд зуучлагдан орж, 697 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна

Хөдөлмөрийн хэлтэст ирсэн 53 ажлын байрны 17(32.1%) нь үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарын захиалга байна. Ажил хайгч 42 иргэн хөдөлмөрийн байгууллагаар дамжуулан ажилд зуучлуулан орсны 26 (61.9%) нь эмэгтэйчүүд байна

Зураг. Бүртгээгүй ажилгүй иргэд сумаар



Зураг. Шинээр ажлын байранд орсон иргэд салбараар





1.5 Нийгмийн даатгал, халамж


Эрүүл мэнд, нийгмийн даатгалын газрын мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2018 оны эхний 03 сард 8107.7 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1475.6 (22.2%) сая төгрөгөөр өссөн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого 2018 оны эхний 03 сард өмнөх оны мөн үеэс 1475.6 сая төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгал 1009.9(24.7%) сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сан 169.1(25.0%) сая төгрөг, эрүүл мэндийн даатгал 134.1(11.0%) сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна

Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого сангийн төрлөөр /сая.төг/ 2018 оны 03 сард



Нийгмийн даатгалын сангийн зарлага 11448.0 сая.төг болж өмнөх оны мөн үеэс 2285.1 (24.9%) сая.төгрөгөөр өссөн байна. Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 7749.2(67.7%) сая.төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 2438.9(21.3%) сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас 601.6(5.3%) сая.төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 485.4(4.2%) сая.төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 172.9(1.5%) сая төгрөгийг зарцуулжээ.

Зураг. Нийгмийн даатгалын зарлага, сая төг







Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээгээр нийгмийн халамжийн сангаас 2018 оны эхний 03 сард нийгмийн халамжийн сангаас 18866 иргэнд 2327.7 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ. Өмнөх онтой харьцуулахад халамж авсан иргэд 4642 (32.6%)-оор, олгосон тэтгэвэр тэтгэмж 752.5 (47.8%) сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Халамжийн тэтгэвэр, тэтгэмж өсөхөд насны хишиг, цалинтай ээж хөтөлбөрт 5472(29.0%) иргэн хамрагдаж, 609.5(26.2%) сая төгрөгийн тэтгэмж олгосон нь нөлөөлсөн байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2018 онд 1267 хүн хамрагдсан нь өмнөх оноос 113 (9.8%)-аар, олгосон тэтгэвэрийн хэмжээ 245.0 (79.2%) сая төгрөгөөр нэмэгджээ. Нийгмийн нөхцөлт мөнгөн тусламжид 968 иргэнд 187.9 сая төгрөг, онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид 798 иргэнд 146.9 сая төгрөг тус тус олгож, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургахад 5671 иргэнд хамруулж 180.5 сая төгрөгийг зарцуулсан байна. Нийгмийн бусад халамжийн шаардлагатай иргэнд үзүүлэх тусламжийг 10162 иргэнд 1258.2 сая төгрөг олгосон байна.

Зураг. Хүний тоо



Зураг. Олгосон тэтгэвэр, тэтгэмж /мян төг/





1.6 Гэмт хэрэг


Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр оны эхний 03 сарын байдлаар 144 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 32 хүн гэмтэж, 4 хүн нас барсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 41(22.2%)-ээр, нас барсан хүний тоо 8(66.7%)-аар, гэмтсэн хүний тоо 28(46.7%) -аар тус тус буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хүний амины гэмт хэрэг 9(75.0%)-өөр, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 15(65.2%)-аар, дээрмийн гэмт хэрэг 1(50.0%)-ээр хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг 16 (33.3%)-аар буурч, авилгын гэмт хэрэг, цэргийн албаны эсрэг гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 63(43.8%) нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 32(22.2%) нь хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, 12(8.3%) нь улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэрэг, 37(25.7%) хувийг нь бусад төрлийн гэмт хэргүүд эзэлж байна. Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 15 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 48(76.2%) -аар буурсан байна.

Гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс Айраг, Алтанширээ, Мандах, Өргөн, Сайхандулаан, Хатанбулаг, Хөвсгөл, Эрдэнэ, Сайншанд, Замын-Үүд сумдад буурсан байна.


Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сумаар



Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 172.2 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 834.5(82.9) сая төгрөгөөр буурсан байна. Учирсан хохирлын 47.6(27.6%) сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

Нийт гэмт хэргийн 42(29.2%) нь гэр сууцандаа, 15(10.4%) нь согтуугаар, 13 (9.0%) нь гудамж олон нийтийн газарт, 12 (8.3%) бүлэглэн, 15 (10.4%) хувийг эмэгтэй хүн оролцон, 43(29.9%) нь, шөнийн цагаар /22.00-06.00 цаг/ үйлдсэн байна. Тайлант хугацаанд нийт 271 хүн эрүүлжүүлэгдэж, 66 хүн баривчлагджээ.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэрэг үйлдэгдсэн цагаар 03 сард




Хоёр. Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт




2.1 Мөнгө, зээл

Монгол банкны мэдээгээр арилжааны банкуудын кассын орлого 231.0 тэрбум төгрөг болж өмнөх оноос 30.0(11.5%) сая төгрөгөөр буурч, цэвэр зарлага 355.7 тэрбум төгрөг болж 103.6(41.1%) сая төгрөгөөр өссөн байна.

Зураг. Хадгаламж эзэмшигч, зээлдэгчийн тоо, 2017- 2018 он, мян.хүн



Зураг. Хадгаламжийн үлдэгдэл, зээлийн өрийн үлдэгдэл, 2017-2018 он, сая.төг




Иргэдийн мөнгөн хадгаламж 82.2 тэрбум төгрөг болж нэг хадгаламж эзэмшигчид дунджаар 1214.3 мянган төгрөг, аймгийн нэг хүнд дундажаар 1205.3 мянган төгрөгийн хадгаламж ногдож байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хадгаламж эзэмшигчийн тоо 1.0 (1.5%) мянган хүнээр, хадгаламжийн үлдэгдэл 18.2(28.5%) тэрбум төгрөгөөр өссөн байна.


Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны 03 дугаар сарын эцэст 4689.3 сая төгрөг болж, өмнөх сараас 397.9(9.3%) сая төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 1366.3(41.1%) сая төгрөгөөр нэмэгджээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 2.2 хувийг эзэлж, өмнөх сараас 0.2 пунктээр, өмнөх оны мөн үеэс 0.4 пунктээр нэмэгджээ.

Чанаргүй зээл 03 дугаар сарын эцэст 7105.4 сая төгрөг болж өмнөх сараас 175.8(2.5%) сая төгрөгөөр өссөн, өмнөх оны мөн үеэс 1609.6(18.5%) сая төгрөгөөр буурсан. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 3.3 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.4 пунктээр буурсан байна.

Зураг. Зээл төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2018.03 сард




Зураг. Зээлдэгчийн тоо, зээлийн төрлөөр, 2018.03 сард



2.2 Орон нутгийн төсөв

2018 оны 03 дугаар сарын байдлаар орон нутгийн төсөвт 7133.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 119.6 хувь байна. Өмнөх оны мөн үетэй төсвийн орлогын дүнг харьцуулахад 35.6 хувиар өссөн байна. Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 64.0 хувийг татварын, 36.0 хувийг татварын бус орлого бүрдүүлсэн байна.

Зураг. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүтэц, хувиар, 2018 оны 03-р сард



Улсын нэгдсэн төсөвт ААНБ-ын орлогын албан татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, ашигт малтмал нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр нийт 1106.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс 162.6(17.2%) сая.төг-өөр нэмэгдэж, тухайн оны төлөвлөгөөнөөс 465.8(72.7%) сая.төг-өөр давуулан биелүүлсэн байна.



2.3 Үнэ

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.


Хэрэглээний үнийн индекс 2018 оны 03 дугаар сард өмнөх сараас 1.3 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 3.3 хувиар өсчээ.

Ерөнхий индекс өмнөх сараас 1.3 хувиар өсөхөд: хүнсний бараа, ундаа усны бүлэг 4.1 хувь, хувцас бөс бараа, гуталын бүлэг 0.3 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 0.3 хувь, эм тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 2.7 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2018 оны 03 дүгээр сарын өөрчлөлт, өмнөх сартай харьцуулсанаар (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2018 оны 03 дугаар сарын өөрчлөлт, сар бүрээр (өмнөх сар=100)




Гурав. Эдийн засгийн статистикийн үзүүлэлт



3.1 Хөдөө аж ахуй

Оны эхний 03 сарын байдлаар төллөвөл зохих эх малын 21.3 хувь буюу 180.0 мянган толгой мал төллөж, төл бойжилт 99.9 хувьтай байна. Өмнөх оны мөн үеийнхээс төллөсөн хээлтэгч 81.3(82.3%) мянган толгойгоор, төл бойжилт 81.8(82.9%) мянган толгойгоор илүү юм.

Зураг. Том малын зүй бусын хорогдол, толгой



Эхний 3-н сарын байдлаар 1304 том мал хорогдож өмнө оны мөн үеэс хорогдол 71.6 хувиар нэмэгдсэн байна. Хорогдол нэмэгдэхэд малын гоц халдварт өвчин буюу шүлхий өвчнөөр 900 мал хорогдсон нь голлон нөлөөлжээ. Дорноговь аймгийн Хатанбулаг, Хөвсгөл, Эрдэнэ, Сайншанд сумдад шүлхий өвчин 2018 оны 02-р сараас эхлэн гарсан бөгөөд тус сумдын өвчний хорогдол аймгийн нийт малын хорогдлын 70.0 хувь байна.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн судалгаагаар Сайншанд суманд 03-р сард ноолуурын дундаж үнэ 93000 төгрөг болж өмнөх оны мөн үеэс 16000 (20.8%) төг-өөр өссөн байна. Харин ингэний сүү 2500 төг, тэмээний шир 15.0 мянган төгрөг, ямааны арьс 15.0 мянган төг-ийн ханштай байна. Эр хонь 100.0-180.0 мян.төг, эр ямаа 70.0-150.0 мян.төг-өөр худалдаалагдаж байна.



3.2 Аж үйлдвэр

Оны эхний 03 сард аж үйлдвэрийн салбарт 28965.7 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 37617.7 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлууллаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 90.2 хувиар өсч, борлуулалт 19.6 хувиар тус тус өссөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 8.6 хувийг төрийн, 91.4 хувийг хувийн өмчийн аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэжээ.

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр авч үзвэл улсын үйлдвэрийн газар 8.6 хувь, компани 90.9 хувь, өрхийн аж ахуй 0.5 хувийг тус тус эзэлж байна.

Статистикийн мэдээлэлд хамрагдсан гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх оны мөн үетэй сувагжуулалт 0.5 мян.м3-ээр, нарийн боов 3.5 тонноор, бялуу 1.6 тонноор, вакуум цонх 612.2 м2-аар, цемент 35.7 мян.тонноор, модон эдлэл 9562.0 мян.төгрөгөөр, дээл 77 ширхэгээр, жижиг оёдол 11733.8 мян.төгрөгөөр тус тус илүү үйлдвэрлэгджээ.

Дөрөв. Байгаль орчны статистикийн үзүүлэлт



4.1 Байгаль орчин Цаг уур

2018 оны 03 дугаар сарын дундаж агаарын температур нутгийн өмнөд хэсгээр 4.0-5.4 хэм дулаан, Дэлгэрэх суманд 0.4 хэм хүйтэн, бусад нутгаар 0.8-2.4 хэм дулаан, агаарын хамгийн их температур өдөртөө нийт сумдын нутгаар 20-22 хэм дулаан байлаа. Агаарын дундаж температурыг олон жилийн дундаж / ОЖД /-тай харьцуулахад: Нийт сумдын нутгаар ОЖД-аас дулаан байлаа. Хөрсний гадарга дээр шөнөдөө 18-25 хэм хүйтэн, өдөртөө Сайхандулаан, Хатанбулаг сумдад 40 хэм дулаан, Мандах суманд 39 хэм дулаан, Иххэт суманд 32 хэм дулаан, бусад сумдын нутгаар 35-38 хэм дулаан байв.

03 дугаар сард нийт сумдын нутгаар 1-3 өдөр хур тунадастай байж, 0.0-2.1 мм хур тунадас орлоо.

Энэ сард салхины хамгийн их хурд Замын-Үүд суманд 23 м/с, Сайншанд, Эрдэнэ сумдад 18-19 м/с, Мандах, Хөвсгөл, Дэлгэрэх, Айраг, Алтанширээ, Иххэт сумдад 16-17 м/с хүрсэн. 10м/с-ээс дээш салхитай хоногийн тоо Замын-Үүд, Хөвсгөл сумдад 22, Эрдэнэ суманд 17, Дэлгэрэх, Мандах, Сайншанд сумдад 14-15, Алтанширээ, Өргөн, Хатанбулаг сумдад 10-12, бусад сумдын нутгаар 3-6 өдөр байлаа.



АГУУЛГА

II. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн байдлын тухай статистикийн тоон мэдээлэл (Эдийн засгийн үйл ажиллагааны ангиллаар)

Нэг. Эрүүл мэнд

- 1.1 Эрүүл мэнд
- 1.2 Төрөлт, эх хүүхдийн эндэгдэл, сумаар
- 1.3 Халдварт өвчний гаргалт, сумаар

Хоёр. Соёл

- 2.1 Соёлын үзүүлэлтүүд

Гурав. Хөдөлмөр эрхлэлт

- 3.1 Ажилгүй иргэдийн тоо, боловсролын түвшингээр
- 3.2 Ажилгүй иргэдийн тоо, сумаар
- 3.3 Ажлын байрны захиалга, эдийн засгийн салбарын ангилалаар
- 3.4 Ажлын байрны захиалга ажил мэргэжлийн ангилалаар
- 3.5 Ажилд зуучилсан иргэд, ажил мэргэжлийн ангилалаар
- 3.6 Шинэ ажлын байранд орсон иргэн, эдийн засгийн салбарын ангиллаар

Дөрөв. Нийгмийн даатгал, халамж

- 4.1 Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, төрлөөр
- 4.2 Нийгмийн даатгалд заавал даатгуулагчийн тоо, олгосон тэтгэврийн хэмжээ
- 4.3 Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан хүний тоо, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ

Тав. Гэмт хэрэг

- 5.1 Бүртгэгдсэн хэргийн тоо төрлөөр, аймгийн дүнгээр
- 5.2 Бүртгэгдсэн хэргийн тоо сумаар

Зургаа. Мөнгө, зээл

- 6.1 Мөнгөн гүйлгээ, зээл
- 6.2 Хадгаламж, зээл, сумаар, сарын эцэст

Долоо. Орон нутгийн төсөв

- 7.1 Орон нутгийн төсвийн орлого, сая төгрөгөөр
- 7.2 Орон нутгийн төсвийн зарлага, сая төгрөгөөр
- 7.3 Орон нутгийн төсвийн орлого, зарлага, сумдаар, сая төгрөгөөр
- 7.4 Улсын нэгдсэн төсөвт төвлөрүүлсэн орлого, сая төгрөгөөр

Найм. Үнэ

- 8.1 Хэрэглээний үнийн индекс
- 8.2 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тариф
- 8.3 Гол нэрийн барааны үнэ, хөрш зэргэлдээ аймгуудаар

Ес. Хөдөө аж ахуй

- 9.1 Мал төллөлт, төл бойжилт
- 9.2 Том малын зүй бус хорогдол
- 9.3 ХАА-н бүтээгдэхүүний үнийн судалгаа, төрлөөр
- 9.4 Малын үнийн судалгаа, сумаар

Арав. Аж үйлдвэр

- 10.1 Нийт бүтээгдэхүүн, борлуулалт, оны үнээр
- 10.2 Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн жигд ажиллагаа
- 10.3 Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, дэд салбараар
- 10.4 Бүтээгдэхүүний үйлдвэрлэл, сумаар, нийт бүтээгдэхүүн гол нэр төрлөөр

Арван нэг. Тээвэр

- 11.1 Тээвэр
- 11.2 Нефть хангамж

Арван хоёр. Байгаль орчин

- 12.1 Цаг уурын үзүүлэлт

Тэмдэглэлийн тайлбар :

- (,,) - тухайн тоо, баримт байхгүй
- (0) - тайлант хугацаанд гүйцэтгэлгүй
- (х) - энэ хүснэгтэнд тоо нөхөгдөхгүй
- (.) - мэдээлэгдэх хугацаа болоогүй



ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ
(2018 ОНЫ 3 ДУГААР САРЫН БАЙДЛААР)

I. Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2015	2016	2017	2018	2018 - 2017	2018
1. Бэлэн хүн ам	мянган хүн	63.1	66.6	68.2	68.5	0.3	100.4
- Төрсөн хүүхдийн тоо*	тоо	380	373	308	352	44	114.3
- Нас барсан хүний тоо - бодит тоогоор**	тоо	70	81	83	90	7	108.4
- Хүн амын цэвэр өсөлт - бодит тоогоор	тоо	310	292	225	262	37	116.4
- Нялхасын эндэгдэл - бодит тоогоор	тоо	2	2	3	4	1	133.3
- 1000 хүүхдэд ноогдох	тоо	8.4	5.4	9.7	11.4	1.6	116.7
2. Халдварт өвчний гаралт - бодит тоогоор	тоо	198	901	307	147	-160	47.9
- 10000 хүнд ногдох	тоо	17.9	54	45	22	-23	47.9
3. Ажилгүй иргэдийн тоо - бүгд	тоо	1 370	1 229	1 711	696	-1 015	40.7
- Үүнээс эмэгтэй	тоо	778	692	891	353	- 538	39.6
- Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүй иргэдийн тоо	тоо	343	290	403	161	- 242	40.0
4. Шинээр бий болсон ажлын байр-бүгд	тоо	22	28	56	3	-53	5.4
Үүнээс: Байнгын ажлын байр	тоо	20	28	56	3	-53	5.4
Улирлын чанартай ажлын байр	тоо	2	0	0	0	0	
5. Гэмт хэргийн гаралт - бодит тоогоор	тоо	158	156	185	144	-41	77.8
- 10000 хүнд ногдох ***	тоо	38	38	43	33	-10	77.5
6.Бойжиж буй төл, мян толгой	толгой	124839.0	106242.0	98745.0	180562.0	81817	183
- Ботго	толгой	1036	597	369	2073	1704	562
- Унага	толгой	692	359	579	1000	421	173
- Тугал	толгой	1854	1027	1090	1583	493	145
- Хурга	толгой	67278	57941	60630	100368	39738	166
- Ишиг	толгой	53979	46318	36077	75538	39461	209
7. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая төгрөг	4019.8	4904.6	15230.3	28965.7	13735.4	190.2
- Борлуулсан бүтээгдэхүүн	сая төгрөг	3430.7	3325.9	31458.7	37617.7	6159.0	119.6

* - 2015, 2016, 2017 оны жилийн эцэст

**-Төрөлт, нас баралтыг ЭМГ-ын мэдээнээс авав.

*** - 18 - аас дээш насны 10000 хүнд ногдохоор тооцов.

**II. ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БАЙДЛЫН ТАНИЛЦУУЛГА****НЭГ. ЭРҮҮЛ МЭНД****1.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхний 03 сарын эцэст**

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 I-III	2018 I-III	Өсөлт	
		тоо		хувь	
1. Амбулаторийн үзлэг	мян.хүн	90.4	87.5	-2.9	96.8
2. Ор хоног	мян.хүн	30.8	32.3	1.5	104.9
3. Урьдчилан сэргийлэх тарилга	мян.хүн	2.9	2.9	0	100.0
4. Эмчлүүлсэн хүний тоо	мян.хүн	4.4	4.6	0.2	104.5
5. Түргэн тусламжын дуудлага	мян.хүн	5.1	5.4	0.3	105.9
Үүнээс: алсын дуудлага	мян.хүн	0.9	0.9	0	100.0
6. Осол гэмтлийн өвчлөл	хүн	637	708	71	111.1
Үүнээс: нас баралт	хүн	22	16	-6	72.7
7. Шинээр хяналтанд авсан жирэмсэн эх	хүн	423	436	13	103.1
Үүнээс: эхний 3 сартайн хяналт	хүн	373	372	-1	99.7
8. Амаржсан эх	хүн	306	352	46	115.0
Үүнээс: нас баралт	хүн	0	0	0	0.0
9. 1-5 хүртэл насны эндсэн хүүхэд	хүн	0	1	1	0.0
10. 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүн	4	4	0	100.0

1.2. ТӨРӨЛТ, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар, жил бүрийн эхний 03 сарын эцэст

Сумын нэр	Амаржсан эх	Эхийн эндэгдэл	Амьд төрсөн хүүхэд	1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	1-5 хүртэл насны эндсэн хүүхэд
Дүн	352	0	352	4	1
Айраг					
Алтанширээ					
Даланжаргалан					
Дэлгэрэх					
Иххэт					
Мандах					
Өргөн					
Сайхандулаан					
Улаанбадрах				1	
Хатанбулаг	1		1		
Хөвсгөл	0				
Эрдэнэ	1		1		
Сайншанд	293		293	1	
Замын - Үүд	57		57	2	1

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар



1.3. БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, төрлөөр, жил бүрийн эхний 03 сарын эцэст

Үзүүлэлт	2017 I-III	2017 I-III	Өсөлт	
	тоо			хувь
Халдварт өвчний гаралт-Бүгд	307	147	-160	47.9
Вируст гепатит	3	1	-2	33.3
Сүрьеэ	28	23	-5	82.1
Тэмбүү	23	23	0	100.0
Заг хүйтэн	42	42	0	100.0
Трихоминиаз	42	15	-27	35.7
Цусан суулга	6	7	1	116.7
Бусад	163	36	-127	22.1

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар

ХОЁР. СОЁЛ

2.1 СОЁЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	Хэмжих нэгж	2017 I-III	2018 I-III	Өсөлт	
				тоо	хувь
1. Театр -тоглолт	тоо	63	52	-11	82.5
- шинэ уран бүтээл	тоо	0	0	0	0.0
- үзэгчид	мян.хүн	11.4	11.2	-0.2	98.2
- орлого	мян.төг	13 060.0	8 207.0	-4 853.0	62.8
- хамрагдсан ААН	тоо	1	1	0.0	0.0
2. Музей					
- үзэгчид	мян. хүн	1.7	0.9	-0.8	52.9
- орлого	мян.төг	1 249.2	830.0	- 419.2	66.4
- хамрагдсан ААН	тоо	2	2	0	0.0



ГУРАВ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

3.1 БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, боловсролын түвшингээр, жил бүрийн 03 сарын эцэст

Боловсролын түвшингээр	2015. III	2016. III	2017. III	2018. III	2018. III 2015. III	2018. III 2017. III
	хүний тоо				хувь	
ДҮН	1 370	1 229	1 711	696	50.8	40.7
Үүнээс: Эмэгтэй	778	692	891	353	45.4	39.6
Магистр, доктор	4	12	7	1	25.0	14.3
Дээд боловсролтой	393	301	413	166	42.2	40.2
Тусгай дунд	139	161	175	34	24.5	19.4
Техник мэргэжлийн	98	144	162	49	50.0	30.2
Бүрэн дунд	444	421	722	392	88.3	54.3
Бүрэн бус дунд	225	147	187	35	15.6	18.7
Бага	55	34	36	6	10.9	16.7
Боловсролгүй	12	9	9	13	108.3	2.2 ²

3.2 АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, жил бүрийн 03 сарын эцэст

	Ажилгүй иргэдийн тоо		Ажилд орсон хүний тоо		Шинээр бүртгүүлсэн хүний тоо	
	2017. III	2018. III	2017. III	2018. III	2017. III	2018. III
ДҮН	1705	696	235	58	578	1005
Айраг	200	15	64	6	72	70
Алтанширээ	21	26	4	5	22	69
Даланжаргалан	60	18	3	0	18	17
Дэлгэрэх	47	20	24	2	66	9
Иххэт	41	14	0	2	0	9
Мандах	95	7	0	10	0	37
Өргөн	73	6	10	1	66	2
Сайхандулаан	47	2	3	0	18	6
Улаанбадрах	32	8	6	6	2	29
Хатанбулаг	46	8	6	0	8	36
Хөвсгөл	32	1	28	4	38	13
Эрдэнэ	27	12	9	1	24	34
Сайншанд	717	360	25	17	188	371
Замын - Үүд	267	199	53	4	56	303

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



3.3 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, эдийн засгийн салбарын ангилал, 03 сарын эцэст

Салбарын ангилал	2017.III	2018.III
	Тоо	
Бүгд	198	53
ХАА, ан агнуур, ойн аж ахуй,загас барилт	9	2
Уул уурхай олборлох аж үйлдвэр	72	8
Боловсруулах үйлдвэрлэл		
Цахилгаан, хий, уур, агааржуулалт		1
Усны хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа		
Барилга	1	
Бөөний ба жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ		
Тээвэр агуулахын үйл ажиллагаа		7
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ		
Мэдээлэл, холбоо		
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1	
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа		
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа		
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа		1
Төрийн удирдлага, батлан хамгаалах, үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	33	8
Боловсрол	16	7
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ	12	2
Урлаг, үзвэр, тоглоом наадам	5	
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	49	17
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, өрхийн өөрийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн нэр төрлөөр нь салгаж тодорхойдох боломжгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ		
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа		

3.4 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ажил, мэргэжлийн ангилал, 03 сарын эцэст

Үзүүлэлт	2017. III	2018. III
	Тоо	
Бүгд	198	53
Менежер	7	
Мэргэжилтэн	66	12
Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн	16	5
Контор, үйлчилгээний ажилтан	9	3
Худалдаа, үйлчилгээний ажилтан	33	8
ХАА, ой загас агнуурын ажилтан	0	2
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан	18	2
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, үгсрагч	21	8
Энгийн ажил мэргэжил	25	10
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	3	3

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



3.5 АЖИЛД ЗУУЧИЛСАН ИРГЭД, ажил, мэргэжлийн ангилалаар 03 сарын эцэст

Үзүүлэлт	2017. III		2018. III	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
	Тоо			
Бүгд	116	66	42	26
Менежер	6	2		
Мэргэжилтэн	23	19	9	7
Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн	9	9	5	5
Контор, үйлчилгээний ажилтан	6	5	3	3
Худалдаа, үйлчилгээний ажилтан	24	16	8	5
ХАА, ой загас агнуурын ажилтан	0	0		
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан	4	0	2	1
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	23	5	2	1
Энгийн ажил мэргэжил	20	9	10	2
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	1	1	3	2

3.6 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД ОРСОН ИРГЭН, эдийн засгийн салбарын ангиллаар, 03 сарын эцэст

Салбарын ангилал	Бүгд	Эмэгтэй	Бүгдээс: Ажлын байрны шинж, чанараар	
			Байнга	Улирал
	Тоо			
Бүгд	7	3	7	0
ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1	0	1	
Уул уурхай олборлолт				
Боловсруулах үйлдвэрлэл				
Цахилгаан, хий уур агааржуулалтын хангамж				
Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент				
Барилга				
Бөөний ба жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	1	1	1	
Тээвэр агуулахын үйл ажиллагаа				
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа				
Мэдээлэл холбоо				
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа				
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа				
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа				
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа				
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгал	3		3	
Боловсрол	1	1	1	
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	1	1	1	
Урлаг үзвэр тоглоом наадам				
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа				
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн аж ахуй				
Олон улсын байгууллагын үйл ажиллагаа				

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



ДӨРӨВ. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

4.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА төрлөөр, жил бүрийн 03 сарын эцэст

	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2018 I-III — 2017 I-III
	2017 I-III	2018 I-III	I-III
	сая төгрөг		хувь
Нийгмийн даатгалын сангийн орлого	6 632.1	8 107.7	122.2
Үүнээс: Тэтгэврийн даатгалын сангийн	4 087.5	5 097.4	124.7
Тэтгэмжийн даатгалын сангийн	463.0	577.7	124.8
Эрүүл мэндийн даатгалын сангийн	1 219.8	1 353.9	111.0
ҮОМШӨ-ний даатгалын сангийн	675.4	844.5	125.0
Ажилгүйдлийн даатгалын сангийн	186.4	234.2	125.6
Нийгмийн даатгалын сангийн зарлага	9 162.9	11448.0	124.9
Үүнээс: Тэтгэврийн даатгалын сангийн	6 753.8	7 749.2	114.7
Тэтгэмжийн даатгалын сангийн	482.8	601.6	124.6
Эрүүл мэндийн даатгалын сангийн	1 351.8	2 438.9	180.4
ҮОМШӨ**-ний даатгалын сангийн	321.4	485.4	151.0
Ажилгүйдлийн даатгалын сангийн	253.1	172.9	68.3

** - ҮОМШӨ- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

4.2 НИЙГМИЙН ДААТГАЛД ЗААВАЛ ДААТГУУЛАГЧДЫН ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 03 сарын эцэст

Үзүүлэлт	ХЭМЖИХ НЭГЖ	2017 I-III	2018 I-III	2018 I-II — 2017 I-
1. Заавал даатгуулагч хүний тоо	тоо	13185	14068	106.7
Үүнээс: Аж ахуй нэгж, байгууллага	тоо	6134	6890	112.3
Төсөвт байгууллага	тоо	7051	7178	101.8
2. Олгосон тэтгэвэр	сая төгрөг	6959.7	7962.4	114.4
Үүнээс: Өндөр насны тэтгэвэр	сая төгрөг	5199.8	5885.8	113.2
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн тэтгэвэр	сая төгрөг	722.5	847.6	117.3
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	сая төгрөг	350.7	382.1	109.0
ҮОМШӨ-ний даатгалын сангийн тэтгэвэр	сая төгрөг	213.6	215.9	101.1
Цэргийн тэтгэвэр	сая төгрөг	473.1	631.0	133.4

Эх үүсвэр: Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс



4.3 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 03 сарын эцэст

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2018 I-III	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2018 I-III
	2017 I-III	2018 I-III	2017I- III	2017 I- III	2018 I-III	2017I- III
	тоо		хувь	мянган төгрөг		хувь
НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ	14224	18866	132.6	1575192.3	2327736.6	147.8
1. Халамжийн тэтгэвэр	1154	1267	109.8	309222.3	554259.8	179.2
Ахмад настны тэтгэвэр	51	54	105.9	11979.7	23021.2	192.2
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр	1103	1213	110.0	297242.6	531238.6	178.7
2 Нөхцөлт мөнгөн тэтгэмж	977	968	99.1	153069.5	187905.4	122.8
Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай, ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэнд олгосон тэтгэмж	902	908	100.7	141530.4	175810.2	124.2
Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгазан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	51	48	94.1	8266.6	10178.3	123.1
Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг мөн хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	4	6	150.0	576.0	1084.0	188.2
Ахмад настаныг гэртээ асрамжилж байгаа иргэн	11	5		1550.9	768.9	49.6
Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн	9	1	11.1	1145.6	64.0	5.6
3. Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн дүн	719	798	111.0	98226.1	146905.5	149.6
16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	300	216	72.0	79275.7	93505.5	117.9
Байнгын асаргаа шаардлагатай 16-с дээш насны иргэн	378	567	150.0	9750.4	37440.0	3.8 ²
Гурав ба түүнээс дээш тооны бага насны /14 хүртэлх насны/ хүүхдэдтэй өрх толгойлсон эх /эцэг/	37	4	10.8	3600.0	360.0	10.0
2 ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмж	1	3	3.0 ²	2000.0	6000.0	3.0 ²
18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	2	1	50.0	2400.0	1200.0	50.0
Гэнэтийн аюул, ослын улмаас орон гэргүй болсон өрх	1	5	5.0 ²	1200.0	6000.0	5.0 ²
Хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн		2			2400.0	
4. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардал						
5. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах зардал	4810	5671	117.9	226084.4	180492.5	79.8
Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлтийн зарцуулалт	3088	3182	103.0	66191.0	51672.0	78.1
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт	82	126	153.7	9814.7	13512.7	137.7
